



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/23/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: [tsaranchimeg@audit.gov.mn](mailto:tsaranchimeg@audit.gov.mn)

## Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Залруулсан алдаа .....	16
4.4 Зөвлөмж .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70272248, Факс: 70272582, Иймэл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/05  
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ  
УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Ц.НАРАНТУЯА ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

**19020252**

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,852,850.00</b>	<b>42,175,640.24</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	23,644,500.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	23,644,500.00
3351	Байгууллагаас авах авлага	-	23,644,500.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	9,852,850.00	12,870,150.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	9,852,850.00	12,870,150.00
35410	Бичиг хэргийн материал	278,400.00	504,400.00
35420	Аж ахуйн материал	8,010,250.00	10,727,150.00
35440	Түлш, шатах тослох материал	-	790,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,564,200.00	848,600.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	5,660,990.24
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	-	5,660,990.24
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>559,227,838.21</b>	<b>538,652,363.73</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	559,227,838.21	538,652,363.73
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	543,033,188.21	522,477,535.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	448,071,392.02	429,901,696.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	(28,464,393.12)	(29,754,896.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,600,000.00	33,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,920,000.00)	(5,040,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	100,031,704.40	103,558,704.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,403,338.88)	(22,457,395.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,525,878.00	19,525,878.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,408,054.21)	(6,856,450.81)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	16,194,650.00	16,174,828.34
39301	Програм хангамж	594,650.00	594,650.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(19,821.66)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,600,000.00	15,600,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>569,080,688.21</b>	<b>580,828,003.97</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>569,080,688.21</b>	<b>580,828,003.97</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	569,080,688.21	580,828,003.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	720,601,014.08	720,601,014.08
51101	Өмч: - төрийн	720,601,014.08	720,601,014.08
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(187,304,029.53)	(167,698,290.73)
51210	Өмнөх үеийн үр дүн	(263,164,510.34)	(179,445,606.49)
51220	Тайлант үеийн үр дүн	75,860,480.81	11,747,315.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	35,783,703.66	27,925,280.62
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>569,080,688.21</b>	<b>580,828,003.97</b>

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,519,047,594.07</b>	<b>2,494,770,219.66</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>283,922,248.07</b>	<b>109,638,085.66</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	283,922,248.07	109,638,085.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	283,922,248.07	109,638,085.66
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	283,922,248.07	109,638,085.66
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,235,125,346.00</b>	<b>2,385,132,134.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,213,097,500.00	2,163,701,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,213,097,500.00	2,163,701,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	22,027,846.00	221,430,734.00
131103	ЗГНХ ЗДНХөрсөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	-	15,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	20,445,426.00	206,430,734.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	1,582,420.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,442,973,497.24</b>	<b>2,465,664,737.30</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,442,973,497.24</b>	<b>2,465,664,737.30</b>
<b>210</b>	<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	609,371,147.83	651,835,990.26
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	270,792,545.42	258,021,648.11
210101	Үндсэн цалин	192,277,067.04	168,585,992.43
210102	Нэмэгдэл	54,921,807.73	75,444,678.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,270,000.00	9,596,000.00
210104	Урамшуулал	12,323,670.65	4,394,976.81
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,696,740.17	32,916,277.85
210201	Тэтгэврийн даатгал	23,453,254.58	23,286,938.61
210202	Тэтгэмжийн даатгал	2,565,700.00	2,592,816.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,052,600.00	2,064,173.15
210204	Ажилгүйдлийн даатгал	493,685.59	450,379.82
210205	Эрүүл мэндийн даатгал	5,131,500.00	4,521,969.77
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	52,235,886.00	51,490,547.00
210301	Гэрэл, цахилгаан	2,243,680.00	1,715,591.00
210302	Түлш, халаалт	47,743,960.00	47,859,328.00
210303	Цэвэр, бохир ус	2,248,246.00	1,915,628.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	187,500,612.07	103,479,575.42
210401	Бичиг хэрэг	4,856,460.00	1,525,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,066,280.00	1,502,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	247,062.00	530,780.00
210404	Ном, хэвлэл	143,200.00	159,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	270,000.00	65,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,789,220.00	1,218,120.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	170,246,541.07	98,477,895.42
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	900,000.00
210502	Хоол, хүнс	-	900,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	853,400.00	2,478,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	25,500.00
210604	Урсгал засвар	853,400.00	2,452,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,728,000.00	108,000.00
210702	Дотоод албан томилолт	1,728,000.00	108,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	22,326,273.00	30,922,990.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	22,326,273.00	30,922,990.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	40,237,691.17	171,518,951.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,240,160.00	230,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,435,870.00	164,274,644.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,561,661.17	7,014,307.88
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,833,602,349.41	1,813,828,747.04
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,832,716,200.00	1,798,013,996.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	995,475,600.00	948,539,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан	836,830,600.00	838,346,096.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	11,128,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	886,149.41	15,814,751.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	886,149.41	15,814,751.04
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>76,074,096.83</b>	<b>29,105,482.36</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	213,616.02	17,358,166.60
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	213,616.02	17,088,166.60
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	270,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(213,616.02)	(17,358,166.60)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>75,860,480.81</b>	<b>11,747,315.76</b>

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр /
						Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	720,601,014.08	35,783,703.66	-263,164,510.34	0.00	493,220,207.40
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>720,601,014.08</b>	<b>35,783,703.66</b>	<b>-263,164,510.34</b>	<b>0.00</b>	493,220,207.40
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	75,860,480.81	0.00	75,860,480.81
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>720,601,014.08</b>	<b>35,783,703.66</b>	<b>-187,304,029.53</b>	<b>0.00</b>	569,080,688.21
D01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>720,601,014.08</b>	<b>35,783,703.66</b>	<b>-187,304,029.53</b>	<b>0.00</b>	569,080,688.21
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>720,601,014.08</b>	<b>35,783,703.66</b>	<b>-187,304,029.53</b>	<b>0.00</b>	<b>569,080,688.21</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	7,858,423.04	0.00	7,858,423.04
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	-7,858,423.04	0.00	0.00	-7,858,423.04
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	11,747,315.76	0.00	11,747,315.76
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>720,601,014.08</b>	<b>27,925,280.62</b>	<b>-167,698,290.73</b>	<b>0.00</b>	<b>580,828,003.97</b>

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,235,125,346.00</b>	<b>2,385,132,134.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,235,125,346.00</b>	<b>2,385,132,134.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,213,097,500.00	2,163,701,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,213,097,500.00	2,163,701,400.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	22,027,846.00	221,430,734.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	-	15,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	20,445,426.00	206,430,734.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,235,125,346.00</b>	<b>2,385,132,134.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,235,125,346.00</b>	<b>2,385,132,134.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>401,722,996.59</b>	<b>571,303,386.96</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	269,871,300.00	258,021,648.11
210101	Үндсэн цалин	191,355,821.62	174,466,126.37
210102	Нэмэгдэл	54,921,807.73	69,564,544.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,270,000.00	9,596,000.00
210104	Урамшуулал	12,323,670.65	4,394,976.81
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,617,985.59	32,916,277.85
210201	Тэтгэврийн даатгал	24,374,500.00	23,286,938.61
210202	Тэтгэмжийн даатгал	2,565,700.00	2,592,816.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,052,600.00	2,064,173.15
210204	Ажилгүйдлийн даатгал	493,685.59	450,379.82
210205	Эрүүл мэндийн даатгал	5,131,500.00	4,521,969.77
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	52,235,886.00	51,490,547.00
210301	Гэрэл, цахилгаан	2,243,680.00	1,715,591.00
210302	Түлш, халаалт	47,789,682.00	47,859,328.00
210303	Цэвэр, бохир ус	2,202,524.00	1,915,628.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,788,062.00	7,726,560.00
210401	Бичиг хэрэг	888,510.00	3,385,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,338,410.00	2,292,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	247,062.00	530,780.00
210404	Ном, хэвлэл	222,200.00	187,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	439,200.00	65,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	652,680.00	1,264,600.00
2105	<b>Нормативт зардал</b>	-	900,000.00
210502	Хоол, хүнс	-	900,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	886,900.00	24,452,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	22,000,000.00
210604	Урсгал засвар	886,900.00	2,452,500.00
2107	<b>Томиллолт, зочны зардал</b>	1,728,000.00	108,000.00
210702	Дотоод албан томиллолт	1,728,000.00	108,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	22,418,933.00	31,072,190.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	22,418,933.00	31,072,190.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,175,930.00	164,615,664.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	278,800.00	230,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,897,130.00	164,385,664.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,833,402,349.41</b>	<b>1,813,828,747.04</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,832,516,200.00	1,798,013,996.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	995,275,600.00	948,539,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан	836,830,600.00	838,346,096.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	11,128,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	886,149.41	15,814,751.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	886,149.41	15,814,751.04
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,163,701,400.00	2,147,887,648.96
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,163,701,400.00	2,147,887,648.96
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	367,368,300.00	360,673,652.96
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	262,393,700.00	258,021,648.11
210101	Үндсэн цалин	175,977,800.00	174,466,126.37
210102	Нэмэгдэл	70,978,500.00	69,564,544.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,659,000.00	9,596,000.00
210104	Урамшуулал	4,778,400.00	4,394,976.81
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,637,400.00	32,916,277.85
210201	Тэтгэврийн даатгал	24,374,500.00	23,286,938.61
210202	Тэтгэмжийн даатгал	2,565,700.00	2,592,816.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,052,600.00	2,064,173.15
210204	Ажилгүйдлийн даатгал	513,100.00	450,379.82
210205	Эрүүл мэндийн даатгал	5,131,500.00	4,521,969.77
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	52,001,900.00	51,490,547.00
210301	Гэрэл, цахилгаан	1,613,000.00	1,715,591.00
210302	Түлш, халаалт	49,092,800.00	47,859,328.00
210303	Цэвэр, бохир ус	1,296,100.00	1,915,628.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,261,400.00	4,257,560.00
210401	Бичиг хэрэг	421,400.00	419,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,293,800.00	2,292,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	531,100.00	530,780.00
210404	Ном, хэвлэл	187,900.00	187,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, а	65,400.00	65,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	761,800.00	761,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,452,500.00	2,452,500.00
210604	Урсгал засвар	2,452,500.00	2,452,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	142,400.00	108,000.00
210702	Дотоод албан томилолт	142,400.00	108,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	3,238,000.00	3,229,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилг	3,238,000.00	3,229,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,241,000.00	8,197,620.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	244,600.00	230,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,996,400.00	7,967,620.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,796,333,100.00	1,787,213,996.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,796,333,100.00	1,787,213,996.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэм	957,194,000.00	948,539,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан	838,811,100.00	838,346,096.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328,000.00	328,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,163,701,400.00	2,147,887,648.96
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,163,701,400.00	2,147,887,648.96
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,163,701,400.00	2,147,887,648.96
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	22	22
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15
620003	Үйлчлэх ажилтан	6	6

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

				/ төгрөгөөр /
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БАЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>12,589,426.00</b>	<b>221,430,734.00</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>12,589,426.00</b>	<b>221,429,734.00</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	12,589,426.00	210,629,734.00	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	519,920.00	-	
210101	Үндсэн цалин	50,000.00	-	
210102	Нэмэгдэл	469,920.00	-	
210105	Гэрээт ажлын хөлс	1,060,000.00	-	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	1,060,000.00	-	
210201	Тэтгэврийн даатгал	9,189,406.00	-	
210202	Тэтгэмжийн даатгал	9,189,406.00	-	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,820,100.00	-	
210204	Ажилгүйдлийн даатгал	1,820,100.00	-	
210205	Эрүүл мэндийн даатгал	12,589,426.00	-	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,589,426.00	-	
210301	Гэрэл, цахилгаан	12,589,426.00	-	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	3,469,000.00	
210401	Бичиг хэрэг	-	2,966,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	503,000.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	900,000.00	
210502	Хоол, хүнс	-	900,000.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	22,000,000.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	22,000,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	27,842,690.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	27,842,690.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	156,418,044.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	156,418,044.00	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	10,800,000.00	
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	10,800,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	10,800,000.00	
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	1,000.00	
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,000.00	
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	221,430,734.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	221,430,734.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	15,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	206,430,734.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой анхан шатны баримтын бүрдүүлэлт болох ө баримт, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн №07/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газар нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэн, боловсрол, соёлын тогтвортой хөгжлийг хангаж, ЕБС, цэцэрлэг, соёл урлагийн болон бусад байгууллага, иргэдэд тасралтгүй, чанартай үйлчилгээг үзүүлэх чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн байгууллага юм.

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох

бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн А/26 тоот тушаалаар дотоод хяналт шалгалт явуулах ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан боловч хяналт шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитаас шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 2,519,047.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 37,785.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 28,339.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 56,366.2 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 18,580.5 мянган төгрөгөөр өссөн байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 42,274.7 мянган төгрөгөөр тогтоогдсон байна.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

#### **Орлого:**

Тус байгууллага 2021 онд улсын төсвөөс 2,163,701.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 221,430.7 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 109,638.1 мянган төгрөг, нийт 2,494,770.2 мянган төгрөг өмнөх оноос 24,277.3 мянган төгрөгөөр буюу 1,0 хувиар буурсан байна.

#### **Зардал:**

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газар 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 2,494,770.2 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 2,385,132.1 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 2,147,887.6 мянган төгрөг зарцуулсан байна.

#### **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:**

Тус байгууллага төрийн сангийн 100140015001 тоот дансанд 2021 онд 2,163,701.4 мянган төгрөгийн орлого, 2,163,701.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140015401 тоот дансанд 221,430.7 мянган төгрөгийн орлого төвлөрч, 221,430.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	23,644.5	23,644.5
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	9,852.9	12,870.2	3,017.3
Нөөцийн бараа /сурах бичиг/		5,660.9	5,660.9
Үндсэн хөрөнгө	559,227.8	538,652.4	(20,575.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>569,080.7</b>	<b>580,828.0</b>	<b>11,747.3</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	569,080.7	580,828.0	11,747.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>569,080.7</b>	<b>580,828.0</b>	<b>11,747.3</b>

Авлагын дансны үлдэгдэл 23,644.5 мянган төгрөг болж 23,644.5 мянган төгрөгөөр өссөн нь Боловсролын мэдээлэл, технологийн төвөөс санхүүжүүлсэн “Контент боловсруулах лаборатори байгуулах” тоног төхөөрөмж худалдан авах 18,994.5 мянган төгрөг, Боловсролын чанарын шинэчлэлийн төслийн сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 5 дугаар шатны хөтөлбөрийн тоног төхөөрөмж авах 2,980.0 мянган төгрөг, бага ангийн сурагчдын гарын авлага тараах материал хэвлүүлэх 1,670.0 мянган төгрөгийн авлага нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12,870.2 мянган төгрөг болж 3,017.3 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 2716.9 мянган төгрөгөөр, шатахуун 790.0 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 538,652.4 мянган төгрөг болж 20,575.4 мянган төгрөгөөр буурсан нь Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 28 тоот тогтоолоор 18,169.6 мянган төгрөгийн үнэтэй 2 өрөө орон сууцыг балансын үнээр худалдах шийдвэрийн дагуу данснаас хассанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 580,828.0 мянган төгрөг болж 11,747.3 мянган төгрөгөөр буурсан нь дахин үнэлэгдсэн хөрөнгө данснаас хасагдсан болон тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 446,610.2 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 446,610.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 78,913.9 мянган төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 367,696.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь цалин, шимтгэл 38,271.4 мянган төгрөгөөр зардлыг бууруулсантай холбоотой байна. Мөн Сангийн сайдын 43 дугаар тогтоолтой холбоотойгоор бараа үйлчилгээний бусад зардал 27,495.0 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардал 7,523.5 мянган төгрөг, томилолтын зардал 5,203.6 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

ЕБС, Цэцэрлэгийн төсвийн төслийг үндэслэн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 1,796,333.1 мянган төгрөгийг нэмж баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,163,701.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,163,701.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,163,701.4 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,17,887.6 мянган төгрөгийг зарцуулж, 15,813.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,147,887.6 мянган төгрөг буюу 99,27 хувьтай байгаа нь цалин, шимтгэлийн зардал 6,093.2 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 9,119.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газар нь Нэмэлт санхүүжилтийн дансанд Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс “Мянган багшийн чуулга уулзалт” арга хэмжээний зардлын санхүүжилтэд 15,000.0 мянган төгрөг, БШУЯ-аас Хүүхэд харах үйлчилгээний санхүүжилтэд 11,934.7 мянган төгрөг, БШУЯ-ны хөтөлбөр-арга хэмжээний зардлаас ариутгал, халдваргүйжүүлэлтийн зардлын санхүүжилтэд 11,408.0 мянган төгрөг, Боловсролын чанарын шинэчлэл төслийн Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрт 155,033.2 мянган төгрөг, Боловсролын үнэлгээний төвөөс Оношлох үнэлгээний шалгалтын бичиг хэргийн зардлын санхүүжилтэд 9,054.8 мянган төгрөг, Боловсролын мэдээллийн технологийн төв ТӨҮГ-с “Контент боловсруулах лаборатори байгуулах” зардалд 19,000.0 мянган төгрөгийн санхүүжилт нийт 221,430.7 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлсэн байна.

Үүнээс бараа үйлчилгээний бусад зардал 156,418.0 мянган төгрөг, багаж, техник, хэрэгсэл 22,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 27,842.7 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 10,800.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 3,469.0 мянган төгрөг, төвлөрүүлэх шилжүүлэг 11,313.9 мянган төгрөг, нийт 221,430.7 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/397 тоот тушаал, Боловсролын мэдээллийн технологийн төв УТҮГ-ын захирлын 2021

оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/24 тоот тушаалаар “Контент боловсруулах лаборатори байгуулах” 66 байгууллагад шаардагдах 1,254,000.0 мянган төгрөгийг хуваарилсан байна. Энэхүү шийдвэрийн дагуу Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газарт 2021 оны 11 дүгээр сарын 30-нд 19,000.0 мянган төгрөгийн санхүүжилт нэмэлт санхүүжилтийн дансанд орсон байна. Дээрх шийдвэрийн дагуу үнийн судалгаа хийж Сод электроник ХХК-тай 2021 оны 12 дугаар сарын 14-нд гэрээ хийж 18,994.5 мянган төгрөгийг 2021 оны 12 дугаар сарын 16-нд шилжүүлсэн боловч аваагүй авлагаар бүртгэсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газар нь тайлант онд ЕБС, цэцэрлэгт тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 957,194.0 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 838,346.1 мянган төгрөг, нийт 1,796,333.1 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 1,787,214.0 мянган төгрөг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 9,119.1 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 1 байна. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг бүрэн байршуулсан эсэхийг шалгасан. Мэдээллийг бүрэн оруулсан байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газар нь нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан 221,430.7 мянган төгрөгийг бусад хууль тогтоомжийн хүрээнд зарцуулан тайлагнасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн гүйлгээний зарлагын баримтыг е баримтаар баталгаажуулж байх, шилэн дансны мэдээллийг бүрэн оруулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох заавар журмын дагуу шинэчлэн мөрдөж ажиллах зэрэг 3 зөвлөмжийг 80.0% хэрэгжүүлэн ажиллаж Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 0118 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгахад мөнгөн гүйлгээний зарлагын баримтыг е баримтаар баталгаажуулж байх гэсэн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, хүүхэд харах үйлчилгээний санхүүжилт авсан иргэд е баримтаар баталгаажуулаагүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

ЕБС, цэцэрлэгийн төсвийн төсөлд тусгагдсан ЕБС, цэцэрлэгт тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн зардлыг шалгах

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 56,967.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, материаллаг 32,100.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага тогтоож, материаллаг бус 24,867.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, дотоод хяналтын үйл ажиллагааны зөрчилд зөвлөмж өгөв.

### **4.1 Залруулсан алдаа**

Байхгүй.

#### **4.1 Төлбөрийн акт**

Байхгүй

### **4.2 Албан шаардлага**

Тайлант оны эцэст Сод электроникс ХХК 19,874.5 мянган төгрөг, Баянбулагийн дэнж 1,670.0 мянган төгрөг, Майтеч ХХК 2,100.0 мянган төгрөг нийт 23,644.5 мянган төгрөгийн бараа материалын үнийг шилжүүлж авлага үүсгэсэн байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар

тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” бол албан шаардлага тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулганы дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс зөрүүтэй байгаа нь нийт 17 байгууллага, иргэний 24,867.2 мянган төгрөгийн е баримтаар нотлогдохгүй дутуу байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын 5 дахь заалт, Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 6.5-д заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” бол албан шаардлага тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Дотоод хяналттай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн А/26 тоот тушаалаар дотоод хяналт шалгалт явуулах ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан боловч хяналт шалгалт хийгдээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 4.1-д “Дотоод хяналт шалгалтыг дараахь чиглэлээр зохион байгуулна” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

###### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 4.1.5-д “өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт” хийх гэсэн чиглэлийн дагуу Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөнд тэтгэвэр, тэтгэмжийн төсөв, хөрөнгийн тооллого, хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд хяналт шалгалт хийх

###### **2.1. Илрүүлэлт:**

Аж ахуйн дансанд бүртгэлтэй 8,455.6 мянган төгрөгийн автомакс, ариутгалын бодисыг сургууль, цэцэрлэгүүдэд тараасныг харилцагч байгууллагатай тооцоо үүсгэлгүй шууд зардалд хаасан байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

## 2.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлэн харилцагч байгууллагад шилжүүлсэн хөрөнгө, бараа материалыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газар	3	32,100.1	0	0	0	0	1	23,644.5	2	8,455.6
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Төв аймгийн Боловсрол, соёл урлагийн газар	1	24,867.2	0	0	0	0	1	24,867.2		
	Нийт дүн	4	56,967.3					2	48,511.7	2	8,455.6